



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

БУСДЫН ШИЛЖҮҮЛСЭН АЛДААТАЙ ГҮЙЛГЭЭГ САЙН ДУРААРАА МЭДЭГДЭЖ, ХОХИРОЛ БАРАГДУУЛСНЫГ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖИЙГ ХЭЛБЭРИЙН ТӨДИЙ АГУУЛСАН ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ХШТ/32

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь такси үйлчилгээнд явж байхдаа иргэн О-ийн андуурч шилжүүлсэн төлбөр тооцооны алдаатай гүйлгээ болох 6,643,350 төгрөгийг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг төлбөр тооцооны алдаатай гүйлгээг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт² зааснаар шүүгдэгчийг 800 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 800,000 төгрөгөөр торгох ял оногдуулсан.
- Давж заалдах шатны шүүхээс** шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- Хяналтын шатны шүүхэд шүүгдэгч гаргасан гомдолдоо** “Тухайн хүн дансны дугаар авч гүйлгээ хийхдээ өөрөө буруу гүйлгээ хийсэн. Би өөрийн

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3701?daterange=2020-01-01%20-%202025-10-13&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”

хүсэл эрмэлзлээр тухайн хүнийг хайж олж, тухайн хүн илүү мөнгө шилжүүлсэн эсэхээ ч мэдэхгүй байхад нь учир байдлыг тайлбарлаж, анхааралгүй шилжүүлсэн мөнгийг нь надад орж ирэх ёстой мөнгө хэмээн андууран хэрэглэснээ тайлбарлаж, тодорхой хэмжээний мөнгийг буцааж олгоод, үлдэгдэл мөнгийг төлөх хугацааг тохирон салсан. Энэхүү тохирсон хугацаанд тооцоог бүрэн барагдуулсан. Гэтэл намайг мөнгө завшсан хэмээн яллан шийтгэсэнд гомдолтой байна. Надад тухайн мөнгийг завших сэдэл огт байгаагүй. Би өөрөө энэ хэргийг илчилсэн, хохирогч төлбөрөө бүрэн авсан зэргийг харгалзан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

4. **Хяналтын шатны шүүхээс** Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарах **бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргүүд нь** бусдын эд хөрөнгийг шунахай сэдэлтээр, шууд санаатайгаар, хууль ёсны эзэмшигчид нь буцааж өгөхгүйгээр бүрмөсөн өөрийн, эсхүл хамаарал бүхий бусад этгээдийн эзэмшилд хууль бусаар шилжүүлэн авах гэсэн санаа зорилгоор үйлдэгдэхээс гадна тухайн эд хөрөнгөнөөс өөртөө, эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдэд эдийн ашигтай байдлыг бий болгож, хууль ёсны өмчлөгчид хохирол учруулсан байдаг онцлогтой.⁽¹²⁾³
5. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлд⁴ заасан гэмт хэргийн хувьд гэмт этгээд бусдын өмчийг өөрт олж авахын тулд урьдаас идэвхтэй үйлдэл хийгээгүй буюу хохирогчийн эд хөрөнгө гэмт этгээдийн эзэмшилд тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас шилжсэний дараа уг **эд хөрөнгийг завших сэдэл төрж, хууль бусаар захиран зарцуулсан** байдлаар илэрнэ.⁽¹³⁾
6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ **хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй**” байхаар заажээ.⁽¹⁶⁾
7. Эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдсан эрх ашигт халдсан гэм буруутай этгээдийн үйлдлийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа зорилго, гэмт үйлдэл болон түүний үр дагаварт хандаж буй сэтгэхүйн хандлага, хохирол, хор уршгийг арилгасан байдал зэрэг нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг харьцуулан үзэхэд тухайн хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ нь ялимгүй буюу Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁴ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйл. “Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших”



- учруулаагүй бол гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж болно.(17)
8. Шүүгдэгчийн хувьд хохирогчийн андуурч шилжүүлсэн мөнгийг захиран зарцуулсан буруутай боловч энэ талаар хохирогч гомдол гаргахаас өмнө өөрийн санаачилгаар хохирогчтой уулзаж, хохирол барагдуулах арга хэмжээ авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “алдаатай гүйлгээг завших” **гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, нийгмийн аюулын хэр хэмжээ ялимгүй** байна. (18)
9. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, прокуророос шүүгдэгчид холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг **гэмт хэргийн шинжгүй** үндэслэлээр хэрэгсэхгүй болгож цагаатгажээ.(20)

---o0o---